

Шинжлэх ухаан, технологийн
сангийн захирлын 2023 оны 10.
сарын 23 өдрийн А/Х тоот тушаалын
хавсралт

УЛААНБААТАР ХОТ
ATA3415 9126813
9019120050

АЛБАН ТУШААЛЫН ТОДОРХОЙЛОЛТ

1. ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

Албан тушаалын тодорхойлолт боловсруулсан үндэслэл

- Төрийн албаны тухай хууль хэрэгжсэнтэй холбогдуулан шинэчлэн боловсруулсан
- Хууль тогтоомжоор байгууллагын чиг үүрэгт өөрчлөлт орсон

Хууль тогтоомжийн нэр огноо:

Албан тушаалын тодорхойлолтыг баталсан
огноо

2023 оны ..дугаар сарын ..

Байгууллагын нэр:

Шинжлэх ухаан технологийн сан

Нэгжийн нэр:

Төслийн хяналт, шинжилгээний хэлтэс

Албан тушаалын нэр:

Салбарын судалгаа, мониторинг хариуцсан
ахлах мэргэжилтэн /байгалийн шинжлэх
ухааны салбарын/

Албан тушаалын ангилал, зэрэглэл:

ТҮ-8

Ажлын цаг

Ажлын өдөр 8 цаг

Ажлын байрны албан ёсны байршил

Улаанбаатар хот 14200, Сүхбаатар
дүүрэг, 8-р хороо, МТҮПаркийн байр, 3-
р давхар

Хөдөлмөрийн нөхцөл:

Хэвийн

Онцгой нөхцөл

Хамаарахгүй

II. АЛБАН ТУШААЛЫН ЗОРИЛГО, ЗОРИЛТ, ЧИГ ҮҮРЭГ

Албан тушаалын зорилго:

Байгууллагын эрхэм зорилго, алсын хараа, чиг үүргийг хэрэгжүүлэх батлагдсан стратеги төлөвлөгөөний зорилтод нийцүүлэн байгалийн шинжлэх ухааны салбарын төсөл сонгон шалгаруулах, гэрээ байгуулах, судалгааны үндсэн чиглэлийн гэрээ байгуулах, санхүүжүүлэх, хяналт тавих, судалгаа боловсруулалтын ажлын үр дүнг сайжруулах, үйлдвэрлэл үйлчилгээнд нэвтрүүлэхэд дэмжлэг үзүүлэх, олон нийтэд түгээн дэлгэрүүлэх, шинжлэх ухаан, технологийн арга хэмжээг зохион байгуулах

Албан тушаалын зорилт:

1. Байгалийн шинжлэх ухааны салбарын төслийн оролцогч байгууллага, хувь хүмүүс, аж ахуйн нэгж, эрдэм шинжилгээ, судалгааны хүрээлэн, төв, лаборатори, эрдэмтдийн багийн төслийн сонгон шалгаруулалт зохион байгуулах, гэрээ байгуулах, үр дүнд хяналт тавих, дүгнэлт гаргах
2. "Итгэмжлэн хадгалагч"-ийн нэгдсэн мэдээллийн санг мэдээллээр баяжуулах, байгалийн шинжлэх ухааны салбарын төслийн үр дүнг сурталчлах, судалгаа хийх, хамтын ажиллагааг өргөжүүлэх
3. Нэгжийн өдөр тутмын үйл ажиллагаанд оролцож, нэгжийн даргын заавар, удирдамж,

Шинжлэх ухаан, технологийн
сангийн захирлын 2023 оны 10
сарын 03 өдрийн А/Х тоот тушаалын
хавсралт

чиглэлийн дагуу ажиллах, хариуцсан чиг үүргийн хүрээнд төлөвлөлт, тайлагнал, гүйцэтгэлийг гаргах, бусад албан хаагчидтай идэвхтэй, үр бүтээлтэй хамтран ажиллах, байгууллагын соёл, ёс зүйг төлөвшүүлэн бэхжүүлэх;

4. Удирдлагаас өгсөн үүрэг, даалгаврыг биелүүлэх, гүйцэтгэлийг тайлагнах, ажлын үр дүнг дээшлүүлэх.

Зорилт	Албан тушаалын гүйцэтгэх чиг үүрэг	Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт	Хариуцлага, оролцооны хэлбэр Туслах - Т, Хариуцан гүйцэтгэх - Г Хянах – Х
1 дүгээр зорилтын хүрээнд	Суурь судалгааны, улсын захиалгат, цөм технологийн болон технологийн туршилт, зүгшрүүлэлтийн болон гадаадтай хамтарсан төслийн саналын давхардал шалгах, гүйцэтгэгч, удирдагчийн өмнө нь хэрэгжүүлсэн төслийн гүйцэтгэлийн байдалд хяналт тавих	Засгийн газрын 2022 оны 497-р журмын дагуу тухайн жилээс эхлэн хэрэгжүүлэх сонгон шалгаруулалтад оролцох төслүүдийн агуулга, үр дүнгийн даалгаврын давхардал, гүйцэтгэгч, удирдагчийн өмнө нь хэрэгжүүлсэн төслийн гүйцэтгэлийн байдалд хяналт тавих	Г
	Докторын дараах инновацийн тэтгэлгийн саналын давхардал шалгах, гүйцэтгэгч, удирдагчийн өмнө нь хэрэгжүүлсэн төслийн гүйцэтгэлийн байдалд хяналт тавих	Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайдын 2011 оны 06 дугаар сарын 14-ны өдрийн 222 тоот тушаалаар батлагдсан “Докторын дараах судалгаанд сайдын нэрэмжит инновацийн тэтгэлэг олгох” журамд заасны дагуу тухайн жилээс эхлэн хэрэгжүүлэх сонгон шалгаруулалтад оролцох грантын агуулга, үр дүнгийн даалгаврын давхардал, гүйцэтгэгч, удирдагчийн өмнө нь хэрэгжүүлсэн төслийн гүйцэтгэлийн байдалд хяналт тавих	Г
	Гадаадтай хамтарсан төслийн саналын давхардал шалгах, гүйцэтгэгч, удирдагчийн өмнө нь хэрэгжүүлсэн төслийн гүйцэтгэлийн байдалд хяналт тавих	Засгийн газрын 2022 оны 497-р журмын тухайн жилээс эхлэн хэрэгжүүлэх сонгон шалгаруулалтад оролцох төслүүдийн агуулга, үр дүнгийн даалгаврын давхардал, гүйцэтгэгч, удирдагчийн өмнө нь хэрэгжүүлсэн төслийн гүйцэтгэлийн байдалд хяналт тавих	Г
	Суурь судалгааны, улсын захиалгат, цөм технологийн болон технологийн туршилт,	Засгийн газрын 2022 оны 497-р журмын дагуу тухайн оноос эхлэн хэрэгжүүлэх	Г

Шинжлэх ухаан, технологийн
сангийн захирлын 2023 оны 10
сарын 03 өдрийн 1/11 тоот тушаалын
хавсралт



зүгшрүүлэлтийн болон гадаадтай хамтарсан төслийн сонгон шалгаруулалт зохион байгуулах, гэрээ байгуулах үед үр дүнгийн даалгаврын боловсруулалтад хяналт тавих, төслийн гэрээ байгуулах	төслүүдийн гэрээг 30 хоногт багтаан байгуулах	
Судалгааны үндсэн чиглэл хэрэгжүүлэх, санхүүжүүлэх гэрээ байгуулах, явцын хяналт тавьж, үр дүнг хүлээн авах	Засгийн газрын 2022 оны 409-р журмын дагуу гэрээг байгуулах, хяналт тавих, үр дүнг хүлээн авах	Г
Инновацийн грант төслийн сонгон шалгаруулалт зохион байгуулах, гэрээ байгуулах үед үр дүнгийн даалгаврын боловсруулалтад хяналт тавих, төслийн гэрээ байгуулах	Засгийн газрын 2018 оны "Инновацийн үйл ажиллагаанд оролцогчид грант олгох журам"-ын 4.1-т заасны дагуу тухайн оноос эхлэн хэрэгжүүлэх төслүүдийн гэрээг 30 хоногт багтаан байгуулах	Г
Суурь, хавсарга судалгааны грантын гэрээ байгуулах үед үр дүнгийн даалгаврын боловсруулалтад хяналт тавих, төслийн гэрээ байгуулах	Боловсрол, шинжлэх ухааны сайдын нэрэмжит грантын дагуу тухайн оноос эхлэн хэрэгжүүлэх төслүүдийн гэрээг 30 хоногт багтаан байгуулах	Г
Залуу судлаачдыг грантын гэрээ байгуулах үед үр дүнгийн даалгаврын боловсруулалтад хяналт тавих, төслийн гэрээ байгуулах	Залуу судлаачдын эрдэм шинжилгээний бага хурал зохион байгуулах, грант олгох журмын дагуу тухайн оноос эхлэн хэрэгжүүлэх төслүүдийн гэрээг 30 хоногт багтаан байгуулах	Г
Гадаадтай хамтарсан төслийн гэрээ байгуулах үед үр дүнгийн даалгаврын боловсруулалтад хяналт тавих, төслийн гэрээ байгуулах	Засгийн газрын 2022 оны 497-р журмын дагуу тухайн оноос эхлэн хэрэгжүүлэх төслүүдийн гэрээг 30 хоногт багтаан байгуулах	Г
Суурь судалгааны, улсын захиалгат, цөм технологийн болон технологийн туршилт, зүгшрүүлэлтийн болон гадаадтай хамтарсан төслийн хэрэгжилтийн явц, үр дүнд хяналт тавьж, ирүүлсэн тайлантай уялдуулан санхүүжүүлэх санал оруулж ажиллах	Засгийн газрын 2022 оны 497-р журмын үргэлжлэн хэрэгжүүлэх төслийн хэрэгжилтийн явц, үр дүнд хяналт тавьж ажиллах	Г
Суурь, хавсарга судалгааны грантын хэрэгжилтийн явц, үр дүнд хяналт тавьж, ирүүлсэн тайлантай уялдуулан	Эрдэм шинжилгээний байгууллага, ажилтанд грант олгох журмын дагуу үргэлжлэн хэрэгжүүлэх	

Шинжлэх ухаан, технологийн
сангийн захирлын 2023 оны 10.
сарын 03 өдрийн 2/12 тоот тушаалын
хавсралт

	санхүүжүүлэх санал оруулж ажиллах	грантын хэрэгжилтийн явц, үр дүнд хяналт тавьж ажиллах	
	Гадаадтай хамтарсан төслийн хэрэгжилтийн явц, үр дүнд хяналт тавьж, ирүүлсэн тайлантай уялдуулан санхүүжүүлэх санал оруулж ажиллах	Засгийн газрын 2022 оны 497-р журмын дагуу үргэлжлэн хэрэгжүүлэх төслийн хэрэгжилтийн явц, үр дүнд хяналт тавьж ажиллах	Г
	Төслийн явцын тайланг гэрээний календарчилсан төлөвлөгөөний дагуу хүлээн авах, явцын тайланг шаардах, мэдээлэл авах, боловсруулах, танилцуулах	Явцын үр дүн сайжирна	Г
	Үргэлжлэн хэрэгжиж байгаа төслийн явцын тайлан ирүүлсэн байдлыг үндэслэн санхүүжүүлэх эсэх талаар Санхүү, төлөвлөлтийн хэлтэст мэдээ хүргүүлж ажиллах	Цаг тухай бүрд тогтмол	Г
	Байгалийн шинжлэх ухааны салбарын төслийн хугацаа хоцорсон тайланг хүлээн авах арга хэмжээ авах, хууль журмын дагуу шийдвэрлүүлэх санал боловсруулах	Цаг тухай бүрд тогтмол	Г
2 дугаар зорилтын хүрээнд	Байгалийн шинжлэх ухааны салбарын судалгаа боловсруулалтын ажлын үр дүнг сурталчлах, сайжруулах, "Итгэмжлэн хадгалагч"-ийн нэгдсэн мэдээллийн санг эрдэм шинжилгээний тайлангийн мэдээллээр баяжуулах	Цаг тухай бүрд тогтмол	Г
	Байгалийн шинжлэх ухааны салбарын төслийн талаарх мэдээллээр цахим хуудас, нэгдсэн санг шинэчлэх, байнгын ажиллагааг хангах	Цахим хуудас, нэгдсэн санг мэдээллээр шинэчилсэн байх	Г
	Харьяа болон салбарын яамд, холбогдох байгууллагын хэрэгцээт судалгааг хийх, мэдээллээр хангах	Шаардлагатай мэдээ, мэдээлэл, судалгааг цаг тухайд нь гаргасан байх	Г
	Дотоодын ижил төстэй судалгаа хийдэг эрдэмтдийн оролцоог дээшлүүлэх талаар сургалт, семинар зохион байгуулах, мэдээллээр хангах	Сургалт, семинар зохион байгуулагдсан байх	Т
	Эрдэмтдийн төслийн үр дүнг бизнесийн байгууллага, хүмүүстэй холбох, үйлдвэрлэхэд туслах	Эрдэм шинжилгээний үр дүнг бизнесийн байгууллагатай холбох	Т

3 дугаар зорилтын хүрээнд	Нэгжийн үйл ажиллагааг үр дүнтэй зохион байгуулахад нэгжийн даргад дэмжлэг үзүүлэх, түүний заавар, удирдамж, чиглэлийн дагуу ажиллах, албан хаагчдын өдөр тутмын үйл ажиллагааны бүтээмжийг нэмэгдүүлэхэд туслалцаа үзүүлэн хамтран ажиллаж, байгууллагын соёлыг төлөвшүүлэн бэхжүүлэх	Гүйцэтгэсэн ажлын үр дүн	Г
	Нэгжийн мэдээлэл, тайлагналыг нэтгэх ажлыг гүйцэтгж, нэгжийн даргад тайлагнах, бусад нэгжүүдтэй ажлын уялдаа холбоог сайжруулах	Боловсруулсан санал, тайлангийн чанар	Г,Х,Т
	Нэгжийн үйл ажиллагааны чиг үүрэгтэй холбоотой хууль, тогтоол, шийдвэрийн биелэлтийг ханган ажиллах	Хууль, тогтоол, шийдвэрийн хэрэгжилтийн байдал	Г
4 дүгээр зорилтын хүрээнд	Удирдлагаас өгсөн үүрэг, даалгаврыг цаг хугацаанд нь өндөр гүйцэтгэлтэй биелүүлэх	Цаг тухай бүрд тогтмол	Г
	Харьяалагдах нэгж, хэлтсийн сар, улирал, хагас жил, жилийн төлөвлөгөөний дагуу ажиллах	Төлөвлөгөөг батлуулан мөрдөж ажиллах	Г
	Монгол Улсын хууль тогтоомжууд болон байгууллагын хөдөлмөрийн дотоод журам холбогдох журмуудыг биелүүлж ажиллах	Холбогдох журмуудыг дагаж мөрдсөн байх	Г
	Байгууллагаас зохион байгуулж буй олон нийтийн ажилд оролцох	Цаг тухай бүрд тогтмол	Г
	Шууд удирдлагаас өгсөн үүргийн дагуу өөрийн ажил мэргэжил, албан тушаалтай ойролцоо чиг үүргийн ажлыг хавсран гүйцэтгэх	Үүрэг, даалгавар биелүүлсэн байх	Г
	Өөрийн ажил үүрэгтэй холбоотой статистик тоон мэдээллүүдийг байгууллагын цахим хуудсанд байрлуулах, удирдлагыг мэдээллээр хангах	Удирдлагыг мэдээллээр бүрэн хангах	Г
	Мэргэжлийн болон гадаад хэлний ур чадварыг дээшлүүлэх	Мэргэжлийн болон гадаад хэлний мэдлэг дээшилсэн байх	Г
	Сургалт семинар, мэргэжил дээшлүүлэх ажиллагааг дэмжих, оролцох, зохион байгуулах	Сургалт, семинар зохион байгуулагдсан байх	Г

Шинжлэх ухаан, технологийн
сангийн захирлын 2023 оны 10
сарын 03 өдрийн 2/12 тоот тушаалын
хавсралт



	Байгууллагаас албан ёсоор олон нийтэд мэдээлээгүй, байгууллагын үйл ажиллагаатай холбоотой, нэр хүндэд харш мэдээллийг хувийн эрх ашгийн сонирхлоор бусдад тараахгүйгээр ажиллах	Байгууллагын нууцыг чанд хадгалах	Г
	Боловсруулж буй албан бичгийг найруулга зүй, зөв бичгийн дүрмийн алдаа, дутагдалгүйгээр албан хөтлөлт болон холбогдох бусад заавар, чиглэл, стандартад нийцүүлж, хуулийн хугацаанд байгууллагын архивт хүлээлгэн өгөх	MNS 5140-1 стандарт, албан хэрэг хөтлөлтийн журам, монгол хэлний зөв бичгийн дүрмийн дагуу хуулийн хугацаанд архивд хүлээлгэн өгсөн байна.	Г
	Байгууллагын баримт бичиг нягтлан шалгах комиссын саналаар баталсан хөтлөх хэргийн нэрийн жагсаалтын дагуу боловсруулж, архивын нэгж болгон, байгууллагын архивт хүлээлгэн өгөх	Шаардлагатай баримт бичгийг цахимжуулж ББНШК-ын саналаар баталсан нэрийн жагсаалтын дагуу боловсруулж архивласан байна.	Г

III. АЛБАН ТУШААЛД ТАВИГДАХ ТУСГАЙ ШААРДЛАГА		
Боловсрол	- Бакалавраас доошгүй зэрэгтэй	
Мэргэжил	- Байгалийн шинжлэх ухаан, математик, статистик /05/	
Мэргэшил	- Хамаарахгүй	
Туршлага	- 5-аас доошгүй жил, үүнээс төрийн албанд 3-аас доошгүй жил ажилласан байх	
Ур чадвар	Дүн шинжилгээ хийх	<ul style="list-style-type: none"> - Нэгжийн эрхлэх аливаа асуудлыг оношлох, задлан шинжлэх; - Гүйцэтгэж буй ажлын явц, үр дүнг тайлагнах; - Баримт бичигт дүн шинжилгээ хийх, үнэлэлт дүгнэлт өгөх; - Мэдээлэл цуглуулах, нэгтгэн боловсруулах; - Бусад.
	Асуудал шийдвэрлэх	<ul style="list-style-type: none"> - Хууль тогтоомжийн хүрээнд асуудлыг шийдвэрлэх хувилбар боловсруулах; - Үл ойлголцлыг эв зүйгээр зохицуулах; - Ашиг сонирхлын зөрчлөөс ангид, шударга байх; - Бусад.
	Манлайлах	<ul style="list-style-type: none"> - Өөрийн мэдлэг чадвар, эерэг мэдээллийг баг, хамт олонтой хуваалцаж, хамтран ажиллах; - Бусадтай харилцан итгэл төрүүлэхүйц, ажил хэрэгч нээлттэй харилцааг бий болгох; - Байгууллагын зорилго, үйл ажиллагааг ойлгох, хүрээлэлд дасан зохицох, үр бүтээмжтэй ажиллах; - Бусад.
	Бусад	<ul style="list-style-type: none"> - Төрийн албан хаагчийн ёс зүй хэм хэмжээг сахиж, ажлын цагийг баримтлан, харилцааны

Шинжлэх ухаан технологийн сангийн захирлын 2023 оны 10 сарын 03 өдрийн 1/12 тоот тушаалын хавсралт



- соёлыг эрхэмлэх;
- Хэрэглээний программ, мэдээллийн дэвшилтэт технологи ашиглах чадвартай байх;
- Төрийн албан хэрэг хөтлөлт, албан бичгийн боловсруулалт, монгол хэл, найруулгын чадвартай байх;
- Албан ажлын хүрээнд олж авсан мэдээллийг нууцлах;
- Бие даан хариуцлага хүлээх, алдаагаа ухамсарлах, шуурхай засах, дүгнэлт хийх чадвартай байх;

IV. АЛБАН ТУШААЛТНЫ ХАРИЛЦАХ СУБЪЕКТ

Албан тушаалыг шууд харьяалан удирдах албан тушаалын нэр:

Төслийн хяналт, шинжилгээний хэлтсийн дарга

Албан тушаалд шууд харьяалан удирдуулах албан тушаалын нэр, тоо:

Бусад харилцах субъект

- Төрийн болон орон нутгийн захиргаан байгууллага;
- Шинжлэх ухааны академи, эрдэм шинжилгээний хүрээлэн, төв;
- Их дээд сургууль;
- Төрийн бус байгууллага, олон улсын байгууллага, төсөл хөтөлбөрүүд;
- Иргэн, хуулийн этгээд, мэргэжлийн байгууллага.

V. АЛБАН ТУШААЛЫН ТОДОРХОЙЛОЛТЫН БАТАЛГААЖУУЛАЛТ

Албан тушаалын тодорхойлолтыг боловсруулсан:

Албан тушаал: Захиргаа, удирдлагын хэлтсийн дарга

..... В.БАТ-ЭРДЭНЭ

2023 оны 09 дугаар сарын 07 - ны өдөр

Албан тушаалын тодорхойлолт баталсан

ШИНЖЛЭХ УХААН, ТЕХНОЛОГИЙН САНГИЙН

ЗАХИРАЛ..... ДОРЖГОЧООГИЙН ОДГЭРЭЛ

..... гарын үсэг, тамга/

Байгууллагын нэр: Шинжлэх ухаан технологийн сан

Шийдвэрийн огноо: Дугаар: 1/12

2023 оны 10 дүгээр сарын 03 - ны өдөр